

**НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

Биелэлт баталгаажуулсан:

Даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

(албан тушаал)



Биелэлт хянасан:

Захиргаа, санхүүгийн
Хэлтсийн дарга

(албан тушаал)

(гарын үсэг)

Биелэлт нэгтгэсэн:

Дотоод ажил, сургалт
хариуцсан ажилтан

(албан тушаал)

(гарын үсэг)

Төсвийн Шууд захирагч

/Х.ЭРДЭНЭБИЛЭГ/

2021.06.18

(огноо)

Нэгжийн дарга

/Ч.ШИНЭЧИМЭГ/

2021.06.17

(огноо)

/Ц.ҮРЭЛМАА/

2021.06.15

(огноо)

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв (мян.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	ХШҮ- ний гүйцэт- гэлийн хувь
					/Эхний хагас жил/		
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
1.1	Зорилт 1. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах	8.951.522.4	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100	Байгууллагын дүрмээр хүлээсэн 7 чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх 10 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа.	85%
1.1.1	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад нягтлан бодох, санхүү, бүртгэлийн үйлчилгээг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч, нярваар дамжуулан иж бүрнээр үзүүлэх	4.489.522.0	Үйлчилгээ үзүүлэх агентлагийн тоо	12	12	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагт санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч 7, агентлаг хариуцсан 6 нярваар дамжуулан ямар нэгэн гомдол саналгүй иж бүрнээр үзүүлэн ажиллалаа.	100%
1.1.2	Байгууллагын 2021 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр авлагагүй ажиллаж, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулан, нягтлан бодох бүртгэлийг оновчтой зохион байгуулж, ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг цаг тухай бүр нь олгох, "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Өр, авлагагүй ажилласан байх	Өр, авлагагүй ажилласан	Өр, авлагагүй ажиллах	Батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу зарцуулж, холбогдох тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь гарган шилэн дансны тухай хуулийн дагуу вэб хуудаст байршуулан ажиллалаа. Гэрээт байгууллагуудын ашиглалт, үйлчилгээний төлбөрийн тооцоог сар бүр хийж, эхний хагас жилийн тайланг нэгтгэн өр авлага үүсгэлгүй ажиллалаа. Мөн 2020 оны жилийн эцсийн тооллогын дүнг хэлэлцэж, актлах шаардлагатай үндсэн хөрөнгийн жагсаалтыг НӨАУГ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн. Үндсэн хөрөнгө, бараа материалын явцын болон эхний хагас жилийн тооллогыг хийж, эд хөрөнгийн бүртгэлд хяналт тавин ажиллалаа.	100%
1.1.3	Нийслэлийн засаг захиргааны байрууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн байгууламжийн хэвийн	3.257.463.0	Төвлөрүүлсэн орлогын мөнгөн дүн	322.839.4	352.253.3	Тайлант хугацаанд НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн ус, дулаан, цахилгаан, мужааны засвар үйлчилгээ,	90%

1	2	3	4	5	6	7	8
	<p>найдвартай, жигд ажиллагааг хангаж ажиллаж, гэрээний дагуу ашиглалт, үйлчилгээний төлбөрийг төвлөрүүлэх</p>					<p>инженерийн байгууламжийн хэвийн найдвартай, жигд ажиллагааг ханган ажиллалаа. Цахилгаан, сантехникийн эвдрэл гэмтэл, мужааны үйлчилгээтэй холбоотой нийт 956 дуудлага ирснийг шуурхай барагдуулж ажилласан ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31%-иар буурсан үзүүлэлттэй байгаа нь үйлчилгээний чанар сайжирсныг харуулж байна. Мөн байруудын хэрэглээний халуун хүйтэн усны ашиглалт 8665 тн байгаа нь 2020 оны мөн үетэй харьцуулбал 77.3 хувиар буурсан байна.</p> <p>НЗЗ-ны 5-н байранд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны 34 агентлагтай “Байр ашиглалтын гэрээ” болон “Гүйцэтгэх гэрээ” байгуулан гэрээний дагуу ажил, үйлчилгээг үзүүлж ажилласан ба гэрээт байгууллагуудын ашиглалт, үйлчилгээний төлбөрийн тооцоог сар бүрийн эхэнд нэхэмжлэхээр хүргүүлж, орлого төвлөрүүлэлтэд тулгалт хийн тооцоо нийлсэн.</p>	
1.1.4	<p>НЗЗ-ны байруудын аюулгүй байдлыг хангах, камержуулалтыг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх</p>	86.400.0	Байруудад гарсан зөрчил	Байруудад аюулгүй байдлын зөрчил гаргаагүй	Байруудад аюулгүй байдлын зөрчил гаргуулахгүй ажиллах	<p>НЗЗ-ны байруудын аюулгүй байдалд жижүүр, харуул хамгаалалтын ажилтнууд 24 цагийн камерын хяналт тавьж ажилласан ба тайлант хугацаанд харуул, хамгаалалттай холбоотой зөрчил, дутагдал гараагүй байна. Мөн байруудын 13 хяналтын хяналтын камер, 2 дэлгэцэд засвар үйлчилгээг хийж, хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.</p>	50%
1.1.5	<p>Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдыг хамгаалах багаж хэрэгслээр хангаж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах</p>	-	Хөдөлмөр хамгаал-лын зөрчил	Зөрчилгүй ажилласан	Зөрчилгүй ажиллах	<p>Инженер, техникийн ажилтнуудад ажлын багаж хэрэгслээр тогтмол хангаж ажилласан ба цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний хүрээн үйлчилгээнд ажиллаж буй ажилтнуудыг халдвар хамгааллын хэрэгслээр хангаж, нэн шаардлагатай хамгаалалтын</p>	80%

1	2	3	4	5	6	7	8
						хэрэгсэл, цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж ажиллалаа. Хөдөлмөр хамгааллын зааварчилгааг тогтмол өгч, хяналт тавьж ажилласан ба тайлант хугацаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа алдагдсан зөрчилгүй байна.	
1.1.6	Нийслэлийн засаг захиргааны 1, 2, 5 дугаар байруудын хурлын заалны ашиглалтыг сайжруулж, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай, жигд ажиллагааг хангах	-	Зохион байгуулагдсан хурлын тоо	949	1000	Тайлант хугацаанд байруудын хурлын танхимуудад НИТХ 3 удаа НЗД-н шуурхай 17, НЗД-ын зөвлөлийн хурал 8, шагналын арга хэмжээ 33, Нийслэлийн Онцгой комиссын хурал 2, бусад хурал 263 удаа болсон ба хурлын захиалгын дагуу хурлын танхимуудын бэлэн байдал, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, зөрчил дутагдалгүй ажиллалаа.	100%
1.1.7	НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгалыг стандарт, зааврын дагуу чанартай хийх	164.315.4	Цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал хийх талбайн хэмжээ	47.503.74 м2	47.503.74 м2	НЗЗ-ны 5-н байр, ННҮТөвийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн гадна орчны 50м хүртэлх талбай, дотор орчны нийт 42.495.1м2 талбайн өдөр тутмын цэвэрлэгээ, үйлчилгээ үзүүлж, цэвэрлэгээний давтамжийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан 2 цаг тутамд ариутгалын бодистой чийгтэй цэвэрлэгээг хийж, ажлын байранд агаар сэлгэлт тогтмол хийн, спиртэн суурьтай гар ариутгагч уусмалыг хэрэглэж, цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах хүрээнд НЗЗ-ны байруудад 1489 удаагийн ариутгал, халдваргүйтэл хийж гүйцэтгэсэн.	100%
1.1.8	Эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээг төрийн албан хаагчдад үзүүлж, хоол цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагыг хангаж ажиллах, төлөвлөгөөт орлогыг төвлөрүүлэх	763.057.6	Орлогын мөнгөн дүн	479.647.1	523.347.8	Тайлант хугацаанд Хангарди ордны зоогийн газар, НЗДТГ, Улаанбаатар чуулгын цайны газруудаар дамжуулан 49.413 хүнд нийтийн хоолны үйлчилгээг стандартын дагуу, эрүүл, чанартай хүнсээр бэлтгэн, мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллалаа.	100%

1	2	3	4	5	6	7	8
1.1.9	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй хүндэтгэлийн хүлээн авалт, хурлын цайны завсарлага, хээрийн үйлчилгээний бэлтгэл ажлыг бүрэн хангаж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх, төлөвлөгөөт орлогыг төвлөрүүлэн ажиллах	190.764.4	Орлогын мөнгөн дүн	119.911.7	130.836.9	Хурлын цай завсарлага, хүндэтгэлийн хүлээн авалтын үйлчилгээг эхний хагас жилийн байдлаар 22 удаа 440 хүнд шуурхай чанартай үзүүлж ажилласан ба үйлчилгээтэй холбоотой санал гомдол гараагүй байна.	100%
1.1.10	Бодлогын болон захирамжлалын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах	-	Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн Хэрэгжилтийг тайлагнасан тоо	8	8	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 9 заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 заалтад нийцүүлэн ажиллахаар хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллалаа. Бодлогын баримт бичгийн явцад хяналт-шинжилгээ хийхэд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 2021 оны эхний хагас жилд хүрэх түвшин 92%-ийн гүйцэтгэлтэй байна. Монгол Улсын 2 хуулийн 16 заалт, Засгийн газрын 1 тогтоолын 9 заалт, Нийслэлийн засаг даргын 12 захирамжийн 12 заалт, НЗД-ын зөвлөлийн хурлын 2 тэмдэглэлийн 10 заалтыг тус тус хяналтад авч хэрэгжилтийг ханган түүнд тогтмол хяналт тавьж ажиллалаа. Тайлант хугацаанд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 99.8%-ийн биелэлттэй байна.	30%
Хоёр. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
2.1	Зорилт 1. Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулах	90.138.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100	Байгууллагын хүний нөөцийн хувийн хэргийн бүрдлийг хангах, хүний нөөцийн бүрдүүлэлт, шилэн сонголт, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, сургалт, нийгмийн баталгааг хангах хүний нөөцтэй холбоотой 4 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа.	95%

1	2	3	4	5	6	7	8
2.1.1	Ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг бүрдлийг хангах, холбогдох судалгааг гаргах	-	Ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн тоо	302	304	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх ажлын хүрээнд шинээр томилогдсон 12 ажилтан, албан хаагчид хувийн хэрэг үүсгэх, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, хувийн хэргийн бүрдлийг ханган ажилласан. Мөн байгууллагын 262 ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг ханган баяжуулалт хийж ажиллалаа.	100%
2.1.2	Сул орон тоог холбогдох хууль, журмын дагуу нөхөх	-	Хүний нөөцийн бүрдүүлэлтийн коэффициент	0.6	0.6-аас ихгүй байх	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас www.khangardi.mn болон зарын нэгдсэн цахим хуудас www.unegui.mn , www.biznetwork.mn байгууллагын мэдээллийн самбарт тус тус тогтмол байршуулж ажиллалаа. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн газар болон дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллалаа. Тайлант хугацаанд ажлын байрны 19 сул орон тоонд 25 ажил горилогч материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн ба анкет, хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж, 12 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ хийлээ. Эхний хагас жилийн байдлаар хүний нөөцийн бүрдүүлэлтийн коэффициент 0.5 байна.	100%
2.1.3	Ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг улирал бүр дүгнэж, цаашид авах арга хэмжээний саналыг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх	-	Ажилтан, албан хаагчдын ур чадвар, үр дүнг дүгнэсэн тоо	8	8	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 тогтоол, тус газрын “Нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, тайлагнах, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу ажилтан, албан хаагчдын 2021 оны 1, 2 дугаар улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх ажлыг тус тус зохион байгуулж, дүнг ажилтан, албан хаагчдад танилцуулж	100%

1	2	3	4	5	6	7	8
						ажиллалаа. Мөн ажилтан, албан хаагчдын 2021 оны 1, 2 дугаар улирлын ур чадварыг дүгнэх ажлын хэсгийг байгуулан ур чадварыг дүгнэж, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу ур чадварын нэмэгдлийг сар бүр тооцон олгосон.	
2.1.4	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	90.138.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	25	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшлыг хангах үүднээс Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2021 онд ажилтан, албан хаагчдад зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг баталсан ба тус төлөвлөгөөнд 26 арга хэмжээ төлөвлөснөөс 13 арга хэмжээг хэрэгжүүлэн давхардсан тоогоор 254 ажилтан, албан хаагчийг сургалтад хамруулан ажиллалаа. Мөн эхний хагас жилийн байдлаар дээд газраас холбогдох албан хаагч бүрээр 28 удаагийн сургалтыг 100 хувь цахимаар зохион байгуулсан. Цаг үеийн нөхцөл байдалд тохируулан төлөвлөгөөд сургалтуудад ажилтан, албан хаагчдыг цахим хэлбэрээр хамруулан ажиллалаа.	80%
2.2	Зорилт 2. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх	18.590.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100	Нийтлэг чиг үүргийн хүрээнд 9 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн ханган ажиллалаа.	81%
2.2.1	2021 онд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Авлига, ашиг сонирхлын зөрчил	Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан	Авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх	Тайлант хугацаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар тус газрын хуулийн үйлчлэлд хамраах албан тушаалын 13 албан хаагч Авилгатай тэмцэх газарт заасан хугацаанд мэдүүлсэн. Хүндэтгэн	80%

1	2	3	4	5	6	7	8
						үзэх шалтгаанаар хойшилсон болон мэдүүлээгүй албан хаагч байхгүй болно.	
2.2.2	Байгууллагын ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг сахиулах, харилцаа хандлагыг дээшлүүлэх, зөрчлийг өмнөх оныхоос ихгүй байлгах	-	Зөрчлийн коэффициент	0.025	0.021-оос ихгүй байх	Ажилтан, албан хаагчдын гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, зөрчлийн шинж байдалд тохирсон хариуцлагын арга хэмжээ авч ажиллалаа. Тайлант хугацаанд 6 ажилтан, албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж ажилласан ба бусад төрлийн зөрчил гараагүй байна. Мөн аливаа зөрчил гарахаас урьдчилан сэргийлж байгууллагын цахим хуудсанд www.hangarid.mn ёс зүйн дүрмийг нээлттэй байршуулж, ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой сургалт, мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Ёс зүйн зөрчлийн гаралт 2020 оны эхний хагас жилд 5 байсан бол 2021 оны эхний хагас жилд гараагүй байна.	70%
2.2.3	Байгууллагын үйл ажиллагаа, ажилтан, албан хаагчдын чиг үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлж ажиллах	-	Үйл ажиллагаанд гарсан зөрчил, дутагдал	Үйл ажиллагаа хэвийн явагдсан		Байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөөг 2020.01.25-ны өдөр газрын даргаар батлуулж хэрэгжилтийг хянан ажиллаж байна. Тайлант хугацаанд: - Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлын хүрээнд НЗЗ-ны 5 байр, ННҮТ-ийн 4 салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд гэнэтийн хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, - Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед буюу нийт ажилтан, албан хаагчдын 30 хүртэл хувиар ажиллаж байх хугацаанд цахимаар ажиллаж буй албан хаагчдын цаг ашиглалтад тогтмол хяналт тавин албан хаагчдын ажлын тайланг өдөр бүр авч,	50%

1	2	3	4	5	6	7	8
						- Газрын даргын баталсан удирдамжийн дагуу зоогийн газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, дүнг газрын даргад танилцуулан, холбогдох албан хаагчдад ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг өгч, зөрчил дутагдлыг арилгуулан ажиллалаа.	
2.2.4	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллах	-	Сэтгэл ханамжийн судалгааны тоо	1	2	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгааг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн болно.	-
2.2.5	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг нэмэгдүүлэхгүй байх	-	Өргөдөл гомдлын Шийдвэрлэлт-тэд гарсан зөрчил	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн зөрчилгүй ажилласан	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн зөрчилгүй ажиллах	Тайлант хугацаанд байгууллагын ажилтан, албан хаагчдаас хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар 50 өргөдөл ирснийг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид биечлэн болон бичгээр танилцуулж ажиллалаа. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 7 цаг 26 минут, өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй болно.	100%
2.2.6	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулах, тоон гарын үсгийг албан хэрэгцээнд бүрэн нэвтрүүлэх	8.150.0	Зөрчлийн тоо	1	1	Тайлант хугацаанд 172 албан бичгийг дээд шатны байгууллага, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, бусад байгууллагад илгээсэн бөгөөд eDoc системийн албан бичиг боловсруулалт цэсийг ашиглан боловсруулж, цахим гарын үсгээр баталгаажуулж ажиллалаа. Байгууллагын үйл ажиллагаанаас 2020 онд үүсч хөтлөгдсөн 277 хадгаламжийн нэгжийг “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын архивын дүрэм”, “Байгууллагын архивын ажлын үндсэн	100%

1	2	3	4	5	6	7	8
						заавар"-ын дагуу ангилж нэр төрөл хугацаагаар нь төрөлжүүлж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээн авсан.	
2.2.7	Байгууллагын худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг дэмжих	-	Нийт худалдан авалтад дотоодын бүтээгдэхүүний эзлэх хувь	70%	70%-аас доошгүй байх	Байгууллагын зоогийн газрын хүнсний бараа материалын 70 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авч, төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	
2.2.8	НЗЗ-ны байруудад гамшгаас хамгаалах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах	-	Гамшгийн эрсдлийн үнэлгээ хийсэн байрны тоо	3	5	Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэсээр батлуулсан байгууллагын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан ба Нийслэлийн засаг захиргааны 3 дугаар байран хана цуурсан байх тул мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулахаар холбогдох байгууллагад албан бичиг хүргүүлсэн.	70%
2.2.9	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудас /www.khangardi.mn/ болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулан олон нийтэд ил тодоор хүргэж ажиллах	10.440.0	Цахим хуудас болон мэдээллийн самбарт тавигдсан мэдээний тоо	191	192	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд 2021 оны эхний хагас жилд үйл ажиллагаатай холбоотой 40, хүний нөөцтэй холбоотой 12, төсөв санхүүтэй холбоотой 28, худалдан авах ажиллагаатай холбоотой 1 мэдээ, мэдээллийг мэдээллийн самбар, цахим хуудас, пэйж хуудас, шилэн дансанд тус тус байршуулж ажилласан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад мэдээ, мэдээллийн давтамж цөөрсөн байгаа тул холбогдох албан хаагчдад зөрчлийг арилгаж ажиллах зөвлөмж өгч ажиллалаа.	80%
Гурав. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							

1	2	3	4	5	6	7	8
3.1	Зорилт 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	900.089.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд нийт 5 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилтийг ханган ажилласан.	40%
3.1.1	Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан холбогдох стандартуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах	-	Хэрэгжүүлж ажиллах стандартын тоо	2	3	Байгууллагад мөрдөгдөж байсан Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага (ННҮГ-01:2019)-ыг 2020 онд “Нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” болгон шинэчилж, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/276 дугаар захирамжаар батлууллаа. Тус стандартыг таниулах сургалтыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн болно. Стандарт, хэмжил зүйн газрын баталсан онцгой байдлын бэлтгэл, хариу арга хэмжээ, сэргээн босгох үйл ажиллагааны үед хэрэглэх 2020 оны MNS ISO 22301:2020, MNS ISO 22320:2020, MNS ISO 22395:2020, MNS ISO 31000:2020 үндэсний стандартууд болон 2021 оны Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент–COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа MNS ISO45005:2021 тус тус холбогдох албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	50%
3.1.2	Нийслэлийн засаг захиргааны байруудын тохижилт, засварын ажлыг батлагдсан төсөвтөө багтаан гүйцэтгэх	900.089.0	Засварын ажлын тоо	10	15	НЗЗ-ны 1, 2, 4 дүгээр байруудын дээврийн засвар, тохижилт, мөн НЗЗ-ны 1 дүгээр байрны гадна фасадны засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.	50%
3.1.3	Байгууллагын зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх	-	Цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний тоо	1	2	Тус заалтын хүрээнд www.erp.ulaanbaatar.mn системд нэмэлт цэс оруулж байгууллагын хурлын заалны захиалгыг цахимаар хүлээн авдаг болгох ажлыг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд уг ажлыг хамтран зохион	0%

1	2	3	4	5	6	7	8
						байгуулах саналыг нийслэлийн Мэдээлэл, технологийн газарт албан бичгээр хүргүүлсэн.	
3.1.4	НЗЗ-ны байрууд, НҮНТ-ын салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий орчинг бүрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	-	Стандарт орчин бүрдүүлэхэд зохион байгуулсан ажлын тоо	1	2	2021 оны 04 дүгээр сард Баянхошуу дэд төвийн авто зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний авто машинд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн.	0%
3.1.5	Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссоос гаргасан шийдвэрийн хүрээнд цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	-	Арга хэмжээ зохион байгуулж буй байр, салбар, дэд төвийн тоо	10	11	Тайлант хугацаанд цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ: Нийт 12 байршилд буюу НЗЗ-ны 5-н байр, НҮНТөвийн 5-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төв зэрэг нийт 42495.1мкв талбайд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Эрүүл мэндийн яамнаас өгч буй заавар зөвлөмжийн дагуу халдвар, хамгааллын дэглэмийг хатуу баримтлан цэвэрлэгээний давтамжийг нэмэгдүүлж 2 цаг тутамд ариутгал, агаар сэлгэлтийг тогтмол хийж, байруудын гадна орчны 50 метр хүртэлх талбайг цэвэрлэж гүйцэтгэж, 21247.55 м.кв талбайд нийт 1489 удаа ариутгал, халдваргүйтэл хийж гүйцэтгэн ажиллалаа. Нийт 11 байршилд Коронавируст халдварын /Ковид-19/ сэжигтэй тохиолдол илэрсэн үед ашиглах тусгаарлах өрөөг шаардагдах материалыг бэлтгэн бэлэн байдлыг ханган ажилласан. Коронавируст халдвараас (Ковид-19) урьдчилан сэргийлэх үүднээс 2021 оны 03 дугаар 22-ний өдөр вакцинжуулалтын ажлыг зохион байгуулсан ба 262 ажилтан, албан хаагчид 1, 2 дугаар тунд бүрэн хамрагдаад байна.	100%